



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 05 сарын 29 өдөр

Дугаар А/16

Улаанбаатар хот

Үзэсгэлэн зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/585 дугаар захирамж, Нийслэлийн Засаг даргын 2022 оны 155 дугаар захирамжаар батлагдсан газрын дүрмийн 7.1.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аялал жуулчлалыг хөгжүүлэх, аялал жуулчлалын салбарт бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудыг нэг цэгээс хэрэглэгчидтэй уулзуулах, аялагч амрагчдыг нэг дороос мэдээ мэдээлэл авах боломжийг олгох зорилгоор “Улаанбаатар травел экспо-2024” аялал жуулчлалын үзэсгэлэнг 2024 оны 05 дугаар сарын 24-26-ны өдрүүдэд Мишээл экспо төвд зохион байгуулсугай.

2. “Улаанбаатар травел экспо-2024” аялал жуулчлалын үзэсгэлэнг зохион байгуулахад шаардагдах 27,500,000 /хорин долоон сая таван зуун мянга/ төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг Агентлаг хариуцсан ахлах нягтлан бодогч (Д.Уянга)-д зөвшөөрсүгэй.


3. Арга хэмжээг зохион байгуулах, ажлын үр дүнг танилцуулж ажиллахыг Бодлогын хэрэгжилтийн хэлтэс (С.Туул)-т даалгасугай.

ДАРГА



Д.БАТСҮХ

Нийслэлийн Засаг даргын 2024 оны
05 сарын 29 өдрийн
тушаал хавсралт



“УЛААНБААТАР ТРАВЕЛ ЭКСПО-2024” ОЛОН УЛСЫН
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ҮЗЭСГЭЛЭНГ ЗОХИОН БАЙГУУЛАХАД
ШААРДАГДАХ ЗАРДАЛ

Д/д	Зардлын нэр	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Нийт үнэ
1	2	3	4	5
1	Тайз хөгжим техник түрээсийн зардал	3 өдөр	1,500,000	4,500,000
2	Талбайн түрээсийн зардал	3 өдөр	2,000,000	6,000,000
3	Мэдээлэлийн сурталчилгааны зардал	3 ширхэг пост* 7 өдөр	1 000 000	1 000 000
4	Талбайн дотоод болон гадна тохижилтын зардал (Хулдаасан хэвлэл, туг анонс)	багц	6,500,000	6,500,000
5	“Жим” дотоодын аялагчдад зориулсан хөтөч сэтгүүл /эх бэлтгэл, дизайн, хэвлэл/	1000ш	5,000	5,000,000
6	Хөтлөгчийн зардал	1 хүн*3 өдөр	500,000	1,500,000
7	Бүүт тохижуулалтын зардал (Эвент арга хэмжээний сурталчилгааны хулдаасан хэвлэл, босоо стэнд, хэвлэл эх бэлтгэл дизайн зардал)	багц	3,000,000	3,000,000
Нийт дүн:				27,500,000